



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖИХ ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖИЛЛАГААГ ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААНД ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ӨВА-2026/05-14-ШТА-НА



Энэхүү аудитын тайлангийн цахим хувилбарыг дээрх QR кодоор, тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг доорх хаягаар авна уу.
www.audit.mn, www.open.audit.mn

Өвөрхангай аймаг дахь Төрийн Аудитын газрын Дарга,
Тэргүүлэх аудитор О.Батжаргал
Утас: 70323253
Цахим шуудан: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер П.Хорлоосүрэн
Утас: 70323108
Цахим шуудан: Khorloosuren@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Баяртогтох
Утас: 70323108
Цахим шуудан: Bayartogtokhb@audit.gov.mn

Аудитор Г.Нинжбадгар
Утас: 70323833
Цахим шуудан: Ninjbadgarg@audit.gov.mn

Аудитор Р.Цэрэндолгор
Утас: 70323833
Цахим шуудан: Tserendolgor@audit.gov.mn

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	3
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	4
ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ	4
БҮЛЭГ 1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан зарим төсөл арга хэмжээ нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна.....	8
1.1. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан нийт төсөл, арга хэмжээний 10.5 хувь нь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдаагүй байна	8
1.2. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын жагсаалтад баталсан байна.....	10
БҮЛЭГ 2. Хөрөнгө оруулалтаар хэрэгжих зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагааг төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй байна.....	12
2.1. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулсан байна.....	12
2.2. Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагааг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй байна.	12
БҮЛЭГ 3. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжүүлсэн байна.	14
3.1. Гүйцэтгэгч их засварын ажлыг батлагдсан зураг төсвийн дагуу хэрэгжүүлсэн байна.	14
3.2. Техник, тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтын дагуу бүрэн нийлүүлсэн байна.....	16
3.3. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний зохиогч болон захиалагчийн хяналтын гэрээг бүрэн хийгээгүй, үүрэг даалгаврын биелэлтийг тооцох ажил хангалтгүй байна.	16
3.4. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжүүлсэн байна.	18
3.5. Нягтлан бодох бүртгэлд 4 их засварын ажлын төсөвт өртгийг зөрүүтэй бүртгэсэн байна.....	19
АУДИТЫН ДҮГНЭЛТ:.....	29
ЗӨВЛӨМЖ:.....	29

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоол үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт-1	Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө /сая.төг/	7
Хүснэгт-2	Орон нутгийн төсвийн 2023-2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө /сая.төг/	7
Хүснэгт-3	Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнүүд /сая.төг/	11
Хүснэгт-4	ХАА амжилттай зохион байгуулсан ТАХ-ний мэдээлэл /сая.төг/	12
Хүснэгт-5	Хэрэгжээгүй төсөл, арга хэмжээнүүд /сая.төг/	15
Хүснэгт-6	ОНТХО-аар хэрэгжсэн автомашин, тоног төхөөрөмжийн мэдээлэл	16
Хүснэгт-7	Захиалагчийн хяналт хийсэн мэдээлэл	16
Хүснэгт-8	ТАХ-нд олгосон санхүүжилт /хөрөнгө оруулалтын ангиллаар, сая.төг/	18

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг-1	Төсвийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн заалт	10
Зураг-2	ХАА зохион байгуулагдсан байдал /төрөл, хувиар/	13
Зураг-3	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын эмнэлгийн гадна фасадны засвар	14
Зураг-4	Хархорин сумын 2 дугаар цэцэрлэгийн гадна фасадны засвар	15
Зураг-5	Арвайхээр сумын 10 дугаар цэцэрлэгийн дээврийн засвар	15
Зураг-6	Арвайхээр сумын 5 дугаар цэцэрлэгийн дээврийн засвар	15
Зураг-7	ОНТХО-ын 2023-2025 оны санхүүжилтийн гүйцэтгэл /хувиар/	18
Зураг-8	ОНТХО-аар хэрэгжсэн ТАХ-ний бүртгэлд тусгасан мэдээлэл /ХО-ын ангиллаар/	19

ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ


№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Хөгжлийн бодлогын бичиг баримтын төрөл	8
Дүрслэл 2	Орон нутгийн хөрөнгө оруулалт, салбараар	9

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт-1	Хавсралт 1 Хөрөнгийг бүртгэлд тусгасан мэдээлэл /сая. төг/	20

Аудитын нэр:	Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн
Аудитын код:	ӨВА-2026/05-14-ШТА-НА
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/179 дүгээр тушаал, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, аудитын дэд төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.
Аудитын зорилт:	<p>Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, тайланг Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.</p> <p>Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ▪ Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт үндэслэлтэй хийгдэж, оновчтой төлөвлөсөн эсэх; ▪ Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан эсэх; ▪ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж, хүлээн авч, санхүүжүүлсэн эсэх;
Аудитын хамарсан хүрээ:	<p>Аудитаар Өвөрхангай аймагт 2025 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн аймгийн ЗДТГ, ГХБХБГ, ОНӨГ, ХААГ, Арвайхээр, Хужирт, Хархорин зэрэг сумдыг хамруулж, талбар дээр ажилласан.</p> <p>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ болон холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөв, магадлалын ерөнхий дүгнэлт, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайлан, баримт материалыг үзэж нотлох баримтаа цуглуулсан.</p>
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу

	<p>аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэн хянах зэрэг судалгааны арга зүйг ашиглан гүйцэтгэж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:</p>	<p>Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер П.Хорлоосүрэн хэрэгжүүлэн гүйцэтгэлийн аудитын багийн Ахлах аудитор Б.Баяртогтох, аудитор Г.Нинжбадгар, Р.Цэрэндолгор нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.</p>
<p>Аудитын тайлангийн бүтэц:</p>	<p>Аудитын тайлан нь аудитын зорилт, дүн, дүгнэлт зөвлөмж, холбогдох байгууллагын санал хэсгээс бүрдсэн.</p>
<p>Хүндрэл бэрхшээл:</p>	<p>Аудитаар талбарт ажиллах төсөв хүрэлцээгүй, цаг хугацаа, хүн хүчний нөөц боломжтой холбоотой аудитын хамрах хүрээ багассан. Мөн эрсдэлтэй асуудлыг бүрэн хамруулж чадахгүй, аудитын дүгнэлт нь хэсэгчилсэн мэдээлэлд тулгуурлах, бодит байдлыг бүрэн илэрхийлэхгүй байх эрсдэл нэмэгдсэн.</p>



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 02/12 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар хөрөнгө оруулалт, их засварын он дамжиж хэрэгжиж буй 7, шинээр хэрэгжих 19 төсөл арга хэмжээг 4,301.2 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан бөгөөд аймгийн ИТХ-ын 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 07/07 дугаар тогтоолоор 347.0 сая төгрөгөөр санхүүжих 2 төсөл арга, хэмжээг жагсаалтаас хассан байна.

Мөн 2025 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 08/01 дүгээр тогтоолоор барилга байгууламж болон их засварын 496.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээг хасаж, 177.6 сая төгрөгөөр санхүүжих 3 төсөл, арга хэмжээг нэмж баталжээ.

Хүснэгт 1. Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө /сая.төг/

Ангилал	Шилжих ТАХ			Шинэ ТАХ		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Тоног төхөөрөмж				2	455.0	455.0
Их засвар	9	1,422.90	509.18	11	1,471.7	1,471.7
Авто зам	1	798.0	200.0			
Бусад				1	1,000.0	1,000.0
Нийт	10	2,220.9	709.2	14	2,926.7	2,926.7

Өвөрхангай аймагт 2023-2025 онуудад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. Орон нутгийн төсвийн 2023-2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө /сая.төг/

	2023	2024	2025
ТАХ-ий тоо	15	23	24
ТАХ-ий төсөвт өртөг	942.7	1,975.2	5,147.6
Тухайн онд санхүүжих дүн	942.7	1,660.0	3,635.8

Дээрх мэдээллээс харахад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний санхүүжилтийн дундаж өсөлт 97.6 хувь байна.

**АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖИХ ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ
ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖИЛЛАГААГ ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААНД ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА.**

Аудитаар 2,637.5 сая төгрөгийн 8 албан шаардлага, 2 зөвлөмж өгч, 2,584.0 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 1 санхүүгийн бус үр өгөөж тооцов.

БҮЛЭГ 1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан зарим төсөл арга хэмжээ нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна.

1.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан нийт төсөл, арга хэмжээний 10.5 хувь нь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5.1-д “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 6.2.7-д “төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх” гэж заасан.

Энэ нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь аймгийн дунд болон богино хугацааны зорилго, зорилтыг хангахад чиглэгдэх шаардлагатайг илтгэж байна.

Дүрслэл 1. Хөгжлийн бодлогын бичиг баримтын төрөл

Дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг

- Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;
- Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр;

Богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг

- Өвөрхангай аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө;
- Орон нутгийн төсөв


Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 02/12 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар хөрөнгө оруулалт, их засварын он дамжиж хэрэгжиж буй 7, шинээр хэрэгжих 19 төсөл арга хэмжээг 4,301.2 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан бөгөөд аймгийн ИТХ-ын 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 07/07 дугаар тогтоолоор 347.0 сая төгрөгөөр санхүүжих 2 төсөл арга, хэмжээг жагсаалтаас хассан.

Мөн 2025 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 08/01 дүгээр тогтоолоор барилга байгууламж болон их засварын 496.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээг хасаж, 177.6 сая төгрөгөөр санхүүжих 3 төсөл, арга хэмжээг нэмж баталжээ.

Тус тогтоолын 2 дугаар хавсралтаар аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, их засварын 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалтыг шилжих хөрөнгө оруулалт, шинэ хөрөнгө оруулалт гэсэн дарааллыг баримтлан баталсан байна.

Батлагдсан төсөл, арга хэмжээний 42.2 хувийг боловсрол, 2.9 хувийг эрүүл мэнд, 3.9 хувийг соёл, 51.1 хувийг бусад салбарт хөрөнгө оруулахаар төлөвлөжээ.

Дүрслэл 2. Орон нутгийн хөрөнгө оруулалт, салбараар



Боловсролын салбарт сүүлийн 3 жилийн дунджаар хамгийн өндөр хувь буюу 38.4 хувиар хөрөнгө оруулахаар төлөвлөсөн нь Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.4.1.5¹, Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2²-т заасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бодлогыг баримталсан байна.

Өвөрхангай аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 1,268.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг тусгагдаагүй байгаа нь нийт төлөвлөсөн санхүүжилтийн 10.5 хувийг эзэлж байна.

Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй төсөл, арга хэмжээнүүд:

- Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх 1,000.0 сая төгрөг
- Арвайхээр сумын хүүхэд залуучуудын паркийн тоглоомын шинэчлэл 268.5 сая төгрөг

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг дунд үйлдвэрийн газар, Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 250307/03-162 дугаар “Ерөнхий нөхцөл тохиролцох, хамтран ажиллах гурван талт гэрээ”-ний дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхээр 1,000.0 сая төгрөгийг төлөвлөн, жагсаалтад баталсан байна.

Дээрх зардлын хувьд Төсвийн тухай хуульд орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгө нь тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихээр тодорхойлсон байхад, Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд орон нутгийн төсвөөс Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд

¹ Сургалтын байгууллагуудын сурч, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

² Боловсролын байгууллагын барилга, байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан, тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлж, цэцэрлэг, сургуулийн анги, бүлэг дүүргэлтийг багасгана.

хөрөнгө олгож болохоор зохицуулсан нь хууль хоорондын зохицуулалт нь уялдаагүй байна.

Зураг 1. Төсвийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн заалт



Өмнөх аудитаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бага өртөг бүхий, урсгал зардлын шинж чанартай ажлыг санхүүжүүлэхгүйгээр тэргүүлэх ач холбогдолтой, хэрэгцээ шаардлагаар нь эрэмбэлсэн, тооцоо судалгаатай ажлуудыг хэрэгжүүлэх дүгнэлт, зөвлөмж өгсөн боловч зөрчлийг давтан гаргасан байна.

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Төсвийн тухай хуульд заасан шаардлагыг хангаагүй, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус, бага өртөг бүхий урсгал зардалд тусгаж болох Арвайхээр сумын гэрлэн дохио, гэрэлтүүлгийн угсралт, суурилуулалтын зардалд 50.0 сая төгрөг төлөвлөж баталсан байна.

Цаашид зөрчлийг таслан зогсоож, Төсвийн тухай хуулийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээ төлөвлөж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага аймгийн Засаг даргад хүргүүлж байна.

1.2. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын жагсаалтад баталсан байна.

Аймгийн Засаг даргын 2024 оны А/553 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг нь боловсролын салбарын 15, эрүүл мэндийн салбарын 3, соёлын салбарын 4, бусад 1, нийт 23 төсөл, арга хэмжээний саналыг ач холбогдлоор нь эрэмбэлж, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг боловсруулсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэхээр баталсан нийт саналаас нэн тэргүүний ач холбогдол, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан эсэхийг эрэмбэлээгүй 7 ТАХ-г баталсан байна. Тухайлбал:

- Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх-/Төсөвт өртөг-1,000.0 сая төгрөг/
- Гучин-Ус суманд Төрийн албан хаагчийн байр барих-/Төсөвт өртөг-200.0 сая төгрөг/
- Хужирт сумын ерөнхий боловсролын 1, 2 сургуулийн дотуур байрны дотор засвар-/Төсөвт өртөг-318.0 сая төгрөг/

- Арвайхээр сумын хүүхэд залуучуудын паркийн тоглоомын шинэчлэл- /Төсөвт өртөг-268.5 сая төгрөг/
- Арвайхээр 5 дугаар сургуулийн авто зогсоол-/Төсөвт өртөг-80.7 сая төгрөг/
- Улсын бүртгэлийн хэлтэс болон Цагдаагийн газрын авто зогсоол-/Төсөвт өртөг-78.5 сая төгрөг/
- Сургуулийн хүүхдийн автобусны зардал-/Төсөвт өртөг-100.0 сая төгрөг/

Мөн аймгийн ИТХ-ын 2024 оны “Аймгийн 2025 оны төсөв батлах тухай” 02/12 дугаар тогтоолын 3.2.1.2.17-д “Төрийн байгууллагуудын урсгал засвар болон шаардлагатай тоног төхөөрөмжийн зардал”-д 314.0 сая төгрөг санхүүжүүлэхээр тусгасан байна.

Дээрх зардлыг аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/49 дугаар захирамжаар дараах төсөл, арга хэмжээнүүдэд санхүүжилт олгохоор хуваарилсан байна.

- Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 100 хүүхдийн дотуур байрын дотор засвар-/Санхүүжих төсөвт өртөг-83.2 сая төгрөг/
- Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн дээврийн засвар-/ Санхүүжих төсөвт өртөг-40.5 сая төгрөг/
- Хайрхандулаан сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны дээврийн засвар-/ Санхүүжих төсөвт өртөг-95.5 сая төгрөг/
- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын эмнэлгийн гадна фасадын засвар-/ Санхүүжих төсөвт өртөг-94.8 сая төгрөг/

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 1,039.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 5 төсөл, арга хэмжээ нь зураг төсөв, техникийн тодорхойлолт, магадлалын ерөнхий дүгнэлтгүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4³ дэх заалтыг зөрчсөн байна.

Хүснэгт 3. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээнүүд /сая.төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Төсөвлөлтийн шаардлага
1	Гучин-Ус суманд Төрийн албан хаагчийн байр барих	200.0	Зураг төсөв, магадлалын ерөнхий дүгнэлтгүй, газрын зөвшөөрөлгүй.
2	Хужирт сумын ерөнхий боловсролын 1, 2 сургуулийн дотуур байрны дотор засвар	318.0	Зураг төсөв боловсруулаагүй.
3	Арвайхээр сумын хүүхэд залуучуудын паркийн тоглоомын шинэчлэл	268.5	Зураг төсөв боловсруулаагүй, техникийн тодорхойлолтгүй.
4	Арвайхээр сумын авто замын уулзварын гэрлэн дохионы шинэчлэл	152.6	Зураг төсөв боловсруулаагүй.
5	Сургуулийн хүүхдийн автобусны зардал	100.0	Техникийн тодорхойлолтгүй.
Нийт дүн		1,039.1	

³ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.



АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

- Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ, ИТХ-ын ээлжит хуралдааны явцад нэмэлтээр 1,045.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ, нийт 7 ТАХ-г нэн тэргүүний ач холбогдол, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан эсэхийг эрэмбэлээгүй ОНХО-аар хэрэгжүүлэхээр баталсан байна.
- Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 314.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор нэн тэргүүний ач холбогдлоор эрэмбэлэгдээгүй 4 ТАХ-нд зардал хуваарилсан байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөлтийн шаардлага хангаагүй 5 ТАХ-г төлөвлөж, баталсан байна.

Төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Зөвлөлөөр хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг үнэлсний үндсэн дээр тусгах шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. Хөрөнгө оруулалтаар хэрэгжих зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагааг төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй байна.

2.1. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/258, А/259, А/261 дугаар тушаалаар батлагдсан тендерийн жишиг баримт бичгийн дагуу тендерийн баримт бичгийг боловсруулсан байна.


Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний 1,926.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байна.

2.2. Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагааг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй байна.

Өвөрхангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны ХАА-ны төлөвлөгөөнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих нийт 2,769.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Зураг 2. ХАА зохион байгуулагдсан байдал /төрөл, хувиар/

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт төсөл, арга хэмжээний 58.8 хувь буюу 10 ТАХ-г нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 41.8 хувь буюу 7 ТАХ-г харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.



Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний 1,926.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 4. ХАА амжилттай зохион байгуулсан ТАХ-ний мэдээлэл /сая.төг/

№	Аймаг, сумын нэр	ХАА зохион байгуулсан ТАХ		ХАА амжилттай зохион байгуулсан ТАХ			
		Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Шалгарсан дүн	Хэмнэлт
1	Аймгийн ХААГ	16	2081.2	12	1,506.70	1,445.00	61.64
2	Уянга сумын ЗДТГ	1	140.0	1	140.0	134.5	5.5
	Богд сумын ЗДТГ		140.0		140.0	0.0	
	Баянгол сумын ЗДТГ		140.0		140.0	139.8	0.2
ДҮН		17	2,501.2	13	1,926.7	1,859.3	67.3

Тайлант онд 574.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ буюу 23.5 хувь нь техникийн тодорхойлолт ирүүлээгүй оройтсон, 1-3 удаа зарлагдсан ч оролцогч ороогүй болон бусад шалтгаанаар төсвийн тодотголоор санхүүжилт нь татагдаж, 1 ТАХ зураг төсөв, техникийн тодорхойлолт байхгүй тул тендер зарлагдаагүй байна.

Төлөвлөсөн ТАХ-ээс 520.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг сумдын Засаг нарт шилжүүлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7⁴-д заасан хугацааг баримтлаагүй байна.

Тухайлбал:

- Гучин-Ус суманд Төрийн албан хаагчийн байр барих ТАХ-г аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/14 дугаар захирамжаар эрх шилжүүлсэн.
- Богд, Уянга сумын Засаг даргын Тамгын газарт суудлын автомашин худалдан авах багцыг 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/56 дугаар захирамжаар, Баянгол сумын Засаг даргын Тамгын газарт суудлын автомашин худалдан авах багцыг 2025 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/383 дугаар захирамжаар тус тус эрх шилжүүлсэн байна.

⁴ 45.7.Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх энэ хуулийн 45.1, 45.2, 45.3, 45.4-т зааснаас бусад төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг харьяалах доод шатны төсвийн захирагчид, эсхүл худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн бол ажлын 10 өдрийн дотор шилжүүлнэ.

Дараах 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажиллагаанд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1⁵, 13.1.2⁶-д заасан хугацааг баримтлаагүй зөрчил илэрсэн. Тухайлбал:

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

- Арвайхээр 5 дугаар сургуулийн авто зогсоол- /төсөвт өртөг 80.7 сая төгрөг / ХАА-г шаардлагад нийцсэн тендер ирээгүй тул 6 удаа зарласан бөгөөд сүүлийн тендерийг 2025 оны 6 дугаар сарын 5-ны өдөр зарлан, 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Мажестик солюшн рөүд ХХК-д гэрээ байгуулах эрхийг олгосон байна.
- Баянгол сумын Засаг даргын Тамгын газарт суудлын автомашин худалдан авах тендерийг аймгийн ХААГ 4 удаа зарласан боловч шаардлагад нийцсэн тендер ирээгүй байна. Аймгийн Засаг даргын 2025 оны 5 дугаар сарын 27-ны А/383 дугаар захирамжаар ХАА-г зохион байгуулах эрхийг тухайн сумын Засаг даргад шилжүүлжээ. Баянгол сумын Засаг даргын захирамжаар үнэлгээний хороо байгуулагдан, 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдөр тендер зарлагдаж, 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Хасу бизнес групп ХХК-д 134.5 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр сонгон шалгаруулсан байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацааг мөрдөж ажиллах албан шаардлагыг аймгийн Худалдан авах ажиллагааны газар, Баянгол сумын ЗДТГ-т хүргүүлэв.

БҮЛЭГ 3. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжүүлсэн байна.

3.1. Гүйцэтгэгч их засварын ажлыг батлагдсан зураг төсвийн дагуу хэрэгжүүлсэн байна.

Аудитаар орон нутгийн төсвийн хөрөнгөөр Арвайхээр, Хархорин, Хужирт сумдад хэрэгжсэн ТАХ-г хамруулан, төсөл, арга хэмжээнүүдийн батлагдсан зураг төсөв, ажлын тоо хэмжээний дагуу гүйцэтгэсэн эсэхийг үзэхэд их засварын ажлыг зураг төсвийн дагуу хийгдсэн байна. Үүнд:

Зураг 3. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын эмнэлгийн гадна фасадын засвар



⁵ 13.1.1.батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;

⁶ 13.1.2.энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох;

Зураг 4. Хархорин сумын 2 дугаар цэцэрлэгийн гадна фасадын засвар



Зураг 5. Арвайхээр сумын 10 дугаар цэцэрлэгийн дээврийн засвар



Зураг 6. Арвайхээр сумын 5 дугаар цэцэрлэгийн дээврийн засвар



Орон нутгийн 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан боловч ТАХ дараах шалтгааны улмаас төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй, төсөв татагдсан тул аймгийн ИТХ-ын 2025 оны 07/07, 08/01 дугаар тогтоолоор тус тус хасах тодотгол хийсэн байна.

Хүснэгт 5. Хэрэгжээгүй төсөл, арга хэмжээнүүд /сая.төг/

д/д	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	Хэрэгжээгүй шалтгаан
		Эхлэх	Дуусах		
1	Гучин-Ус суманд Төрийн албан хаагчийн байр барих	2025	2025	200.0	Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй тул төсөв татагдсан.
2	Бүрд сумын ерөнхий боловсролын	2025	2025	196.0	ХАА-ны үр дүнд СЯ-руу гомдол гарсантай холбоотой, хугацаа

	сургуулийн дотуур байрын гадна фасадын засвар				хойшилсон учир Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсөв татагдсан.
3	Арвайхээр сумын хүүхэд залуучуудын паркийн тоглоомын шинэчлэл	2025	2025	268.5	Зураг төсөв, техникийн тодорхойлолт байхгүй тул тендер зарлагдаагүй төсөв татагдсан.
4	Улсын бүртгэлийн хэлтэс болон Цагдаагийн газрын авто зогсоол	2025	2025	78.5	Тендер 3 удаа зарласан боловч оролцогч ороогүй, ХАА амжилтгүй болж төсөв татагдсан.
5	Сургуулийн хүүхдийн автобусны зардал	2025	2025	100.0	Төсөв багаар төлөвлөсөн учир оролцогч ороогүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсөв татагдсан.
НИЙТ				843.0	

3.2. Техник, тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтын дагуу бүрэн нийлүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 449.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй автомашин, тоног төхөөрөмж нийлүүлэх 2 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн байна.

Хүснэгт 6. ОНТХО-аар хэрэгжсэн автомашин, тоног төхөөрөмжийн мэдээлэл /сая.төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг
		Эхлэх	Дуусах	
1	Арвайхээр сумын камерын хяналтын системийн засвар, арчилгаа тохируулгад ашиглах автовишк	2025	2025	34.9
2	Баянгол, Богд, Уянга сумдын Засаг даргын Тамгын газарт суудлын автомашин	2025	2025	134.5
		2025	2025	140.0
		2025	2025	139.8
Нийт				449.2

Автомашин, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл, арга хэмжээнүүд техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт туссан үзүүлэлт, тоо хэмжээний дагуу нийлүүлсэн байна.

3.3. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний зохиогч болон захиалагчийн хяналтын гэрээг бүрэн хийгээгүй, үүрэг даалгаврын биелэлтийг тооцох ажил хангалтгүй байна.

Захиалагчийн хяналтын талаар:

Аймгийн орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжих 10 барилга байгууламжийн засварын ажилд техникийн хяналт гүйцэтгүүлэхээр гэрээг байгуулж, захиалагчийн хяналтыг нэг барилга байгууламж дээр дунджаар 5-аас доошгүй удаа очиж хяналт хийхээр хуваарийг баталсан байна.

Аудитын явцад ирүүлсэн судалгаагаар захиалагчийн хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 7. Захиалагчийн хяналт хийсэн мэдээлэл

№	Хяналт тавьсан байгууллага	Хяналт хийсэн ТАХ-ний тоо
1	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	10
2	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	2

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь дараах 2 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

- Арвайхээр 5 дугаар сургуулийн авто зогсоол
- Арвайхээр сумын авто замын уулзварын гэрлэн дохионы шинэчлэл

Авто зам, зогсоолын ажлын хувьд захиалагчийн хяналт хийх эрх бүхий хувь хүн, хуулийн этгээд байхгүй тул захиалагчийн хяналт хийх гэрээ хийгээгүй байна.

Аудитаар барилга, байгууламжийн их засварын ажлын захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэгч нь хяналтыг хэрхэн хэрэгжүүлсэн талаар хянан үзэхэд:

- Захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд гүйцэтгэгчид өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг бүрэн тооцоогүй, биелэлтийн талаарх тэмдэглэл хангалтгүй, үе шатны ажилд өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гүйцэтгэгчээр гаргуулж, дүгнээгүй байна.
- Их засварын ажлын захиалагчийн болон зохиогчийн хяналт хэрэгжүүлэх явцдаа өмнөх хяналтаар илрүүлсэн алдаа зөрчлийн биелэлтийг гүйцэтгэх хугацаа өгдөггүй, барилга дээр очиж явцын хяналт хийсэн тоо, баримт хангалтгүй байна.

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.4.1.1. "төсвийн ерөнхийлөн захирагчийн шилжүүлсэн эрхийн дагуу захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх гэрээг төсөл, арга хэмжээ тус бүрээр захиалагчтай байгуулах;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, гэрээг нэгдсэн байдлаар хийсэн байна.
- Аймгийн ГХБХБГ, ХБТХОХ-ээс захиалагчийн хяналтад тавих дотоод хяналт сул байна. Захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд нь хяналт хийсэн тухай бүр тэмдэглэл үйлдэж, гүйцэтгэгч байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар, түүний биелэлтийн талаар тэмдэглэж, ажлын гүйцэтгэлд хавсаргана гэж заасныг хэрэгжүүлээгүй, гүйцэтгэгчид өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн тэмдэглэл дутуу үйлдсэн байна.
- Аймгийн ГХБХБГ болон ХБТХОХ нь захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дээрх зөрчлүүдэд "Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийсэн хөрөнгө оруулалтын хяналтын тогтолцоо, захиалагчийн хяналтын үр нөлөө" нийцлийн аудитаар албан шаардлага, зөвлөмж хүргүүлсэн байна.

Зохиогчийн хяналтын талаар:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх дараах 9 ТАХ-ний барилгын засварын ажил гүйцэтгэх гэрээнд зохиогчийн хяналтын зардлыг нийт 10.6 сая төгрөгийг тусгаж өгсөн боловч тухайн ажлуудын зохиогчтой гэрээг байгуулаагүй, хяналт хийгдээгүй, санхүүжилт олгогдоогүй байна.

- Зүүнбаян-улаан сумын сантехникийн засвар- 1.3 сая төгрөг
- Есөнзүйл сумын Эрүүл мэндийн төвийн засвар- 0.8 сая төгрөг
- Хархорин сумын 2 дугаар цэцэрлэгийн гадна фасадын засвар-1.6 сая төгрөг

- Арвайхээр сумын 5, 10 дугаар цэцэрлэгийн дээврийн засвар-1.5 сая төгрөг
- Уянга сумын 1 дүгээр цэцэрлэгийн ариун цэврийн өрөөнүүдийн засвар-1.1 сая төгрөг
- Зүүнбаян-улаан сумын ерөнхий боловсролын сургуулийн гадна фасадын засвар-0.8 сая төгрөг
- Богд сумын ерөнхий боловсролын дээврийн засвар-0.8 сая төгрөг
- Төгрөг сумын ЕБС-ийн дотуур байрны дээвэр, шалны засвар-1.2 сая төгрөг
- БОЭТ-ийн Халдвартын эмнэлгийн гадна фасад-1.4 сая төгрөг

Цаашид орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй их засварын ажлын чанар, гүйцэтгэлийг сайжруулахын тулд захиалагч болон зохиогчийн хяналтыг тогтмол, үр дүнтэй хэрэгжүүлэх, үүрэг хариуцлагыг сайжруулах шаардлагатай байна.

3.4. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.6 дахь заалтад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэж заажээ.

Зураг 7. ОНТХО-ын 2023-2025 оны санхүүжилтийн гүйцэтгэл /хувиар/

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл сүүлийн 3 жилийн дунджаар 86.5 хувьтай байна.



Өвөрхангай аймгийн орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар 24 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, 3,635.9 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталснаас, гүйцэтгэлээр 24 төсөл, арга хэмжээнд 86.0 хувь буюу 2,731.0 сая төгрөгийн санхүүжилтийг гэрээнд заасны дагуу олгож, 97.8 сая төгрөгийг чанарын баталгаа болгож хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд, зураг төсвийн үнэ 14.8 сая төгрөг, зохиогч болон техник хяналтын зардлын 43.3 сая төгрөг, 1 ТАХ-ний санхүүжилтийн гүйцэтгэл 200.0 сая төгрөгийг техник хяналтын дансанд шилжүүлсэн байна.

Хүснэгт 8. ТАХ-нд олгосон санхүүжилт /хөрөнгө оруулалтын ангиллаар, сая.төг/

№	Аймаг, сумын нэр	Хөрөнгө оруулалтын ангилал								Нийт дүн	
		Их засвар		Тоног төхөөрөмж		Авто зам, зогсоол		Бусад зардал			
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Аймаг	17	1,709.8	1	34.9	3	419.6	2	550.0	23	2,714.3
2	Уянга сум			1	134.5					1	134.5
3	Богд сум				140.0					0	140.0

4	Баянгол сум			139.8					0	139.8	
	ДҮН	17	1,709.8	2	449.2	3	419.6	2	550.0	24	3,128.6

Хүснэгтээс харахад нийт санхүүжилтийн 54.7 хувийг их засвар, 14.4 хувийг тоног төхөөрөмж, 13.4 хувийг авто зам, зогсоол, гэрлэн дохионы ажил, 17.6 хувийг хөрөнгө оруулалтын шинж чанаргүй бусад зардал, эх үүсвэрийг санхүүжүүлэхэд тус тус зарцуулжээ.

3.5. Нягтлан бодох бүртгэлд 4 их засварын ажлын төсөвт өртгийг зөрүүтэй бүртгэсэн байна.

Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 12/01 дугаар тогтоолоор улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр 2025 онд бий болсон хөрөнгийн эзэмшигчийг тогтоон, хөрөнгө бүртгэх шийдвэр гарсан байна.

Тус тогтоолын дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж ашиглалтад орсон 1,678.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга байгууламжийн их засвар, 449.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй автомашин, тоног төхөөрөмж, 224.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй авто зогсоол, гэрлэн дохионы шинэчлэлийн ажлыг нягтлан бодох бүртгэлд тусгасан байна. /Хавсралт 1/

Зураг 8. ОНТХО-аар хэрэгжсэн ТАХ-ний бүртгэлд тусгасан мэдээлэл /ХО-ын ангиллаар/



Харин орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 1 ТАХ-ний санхүүжилтийн гүйцэтгэл 200.0 сая төгрөгийг үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй тул гүйцэтгэгчид олгоогүй, техник хяналтын дансанд байршуулж, санхүүгийн тайланд дуусаагүй үйлдвэрлэл дансанд тусгасан байна.

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аймгийн ИТХ-ын 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 12/01 дүгээр тогтоолоор бүртгэлд тусгах хөрөнгийн дүнг зөрүүтэй тогтоосноос дараах 2 ТАХ-г нягтлан бодох бүртгэлд зөрүүтэй тусгасан байна. Тухайлбал:

- Хужирт сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн дотуур байрны засварын дүнг 3.5 сая төгрөгөөр илүү, Хужирт сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн дотуур байрны засварын дүнг 3.5 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн;
- Арвайхээр сумын 5 дугаар цэцэрлэгийн дээврийн засварын дүнг 65.4 мянган төгрөгөөр илүү, Арвайхээр сумын 10 дугаар цэцэрлэгийн дээврийн засварын дүнг 65.4 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн;

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2⁷, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4⁸, 14.4.2⁹-т заасныг зөрчсөн тул үндсэн хөрөнгөд зөрүүтэй бүртгэсэн дүнг залруулах хугацаатай албан шаардлагыг холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



⁷ 6.2 Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна.

⁸ 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:

⁹ 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

Тайлангийн хавсралт:

Хавсралт 1 Хөрөнгийг бүртгэлд тусгасан мэдээлэл /сая. төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Бүртгэлд авах эзэмшигч байгууллагын нэр	Бүртгэлд тусгах хөрөнгийн дүн	Гүйцэтгэгчийн нэр	Улсын комиссын акт	
					Огноо	Дугаар
1	Хархорин сумын 2 дугаар цэцэрлэгийн гадна фасадны засвар	Хархорин сумын 2 дугаар цэцэрлэг	191.3	Цаст констракшн	2025-08-27	БЗ-17/2025
2	Уянга сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотор засвар	Уянга сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль	71.7	Арвайн цамхаг ХХК	2025-08-08	БЗ-19/2025
3	Уянга сумын 1 дүгээр цэцэрлэгийн ариун цэврийн өрөөнүүдийн засвар	Уянга сумын 1 дүгээр цэцэрлэг	128.0	Бага хайлантай ХХК	2025-09-15	БЗ-19/2025
4	Сант сумын ЕБС-ийн дотуур байрны дээврийн засвар	Сант сумын Ерөнхий боловсролын сургууль	72.9	Лорд хаус ХХК	2025-05-01	БЗ-02/2025
5	Сант сумын цэцэрлэгийн сантехникийн засвар	Сант сумын цэцэрлэг	59.7	Ундрага байгууламж ХХК	2025-07-25	БЗ-08/2025
6	Зүүнбаян-Улаан сумын ерөнхий боловсролын сургуулийн гадна фасадны засвар	Зүүнбаян-Улаан сумын ЕБС	99.6	Пүүлүүбумба ХХК	2025-07-07	БЗ-07/2025
7	Хужирт сумын ерөнхий боловсролын 1, 2 сургуулийн дотуур байрны дотор засвар	Хужирт сумын 1-р сургууль	139.7	Энхтэргүүн констракшн	2025-09-08	БЗ-18/2025
		Хужирт сумын 2-р сургууль	146.6			
8	Арвайхээр сумын камерын хяналтын системийн засвар, арчилгаа тохируулгад ашиглах автовишк	Төрийн үйлчилгээний мэдээллийн төв	34.9	"Арвай нэт" ХХК	2025-07-22	ОНХС/2025-01
9	Арвайхээр сумын 5, 10 дугаар цэцэрлэгийн дээврийн засвар	Арвайхээр сумын 5 дугаар цэцэрлэг	88.8	Лорд хаус ХХК	2025-07-03	БЗ-06/2025
		Арвайхээр сумын 10 дугаар цэцэрлэг	88.9		2025-07-04	БЗ-06/2026
10	Арвайхээр 5 дугаар сургуулийн авто зогсоол	Арвайхээр сумын ЕБ-ын 5 дугаар сургууль	80.0	Мажистик солишн рөүд ХХК	2025-08-04	АКТ/06/2025

11	Арвайхээр сумын авто замын уулзварын гэрлэн дохионы шинэчлэл	Арвайхээр сумын Нийтийн тээвэр гэрэлтүүлэг ОНӨААТҮГ	144.5	Дэвших стандарт ХХК	2025-07-08	АКТ/01/2 025
12	Хөгжимт драмын театрын дээврийн засвар	Аймгийн Хөгжимт драмын театр	320.0	Сонор бүрд ХХК	2025-08-06	БЗ-13/2025
13	Богд сумын ерөнхий боловсролын сургуулийн дээврийн засвар	Богд сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль	98.5	Дулаан булаг ХХК	2025-10-15	БЗ-22/2025
14	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын эмнэлгийн гадна фасадны засвар	Бүсийн Оношилгоо, Эмчилгээний төв	172.5	Шоо констракшн	2025-06-09	БЗ-04/2025
15	Баянгол, Богд, Уянга сумдын Засаг даргын Тамгын газарт суудлын автомашин	Баянгол сумын ЗДТГ	134.5	Хасубизнес ХХК	2025-07-09	ӨВАБГЗ ДТГ/2025 0102031
		Богд сумын ЗДТГ	140.0	Өвөр булган уул ххк	2025-04-07	№01
		Уянга сумын ЗДТГ	139.8	Ткон консракшн ХХК	2025-03-26	№01
ДҮН			2,351.9			

Тайлан баталгаажуулах тушаал:



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/15

Арвайхээр сум

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/175 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын гуравдугаар хавсралтын 3 дахь заалт, 2025 оны А/161 дүгээр тушаалаар баталсан “Аудитын шийдвэр, түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, аудитаар тогтоосон албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитын тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж ажиллахыг ахлах аудитор (Б.Баяртогтох)-д үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллан, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (О.Пүрэвдорж), Худалдан авах ажиллагааны газрын дарга (Ц.Болдбаатар), Баянгол сумын Засаг дарга (Я.Жаргалмаа), Хужирт сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн захирал (Б.Жамъянсүрэн), Хужирт сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн захирал (Ш.Баярмаа), Арвайхээр сумын 5 дугаар цэцэрлэгийн эрхлэгч (Б.Жаргалмаа), Арвайхээр сумын 10 дугаар цэцэрлэгийн эрхлэгч (Ч.Дониддэмбэрэл) нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Аудитын менежер (П.Хорлоосүрэн), Ахлах аудитор (Б.Баяртогтох) нарт даалгасугай.

8225010032

D:\Audiitiin gazarl\Baiguullagiin dotood barimt\Tushaal

5. “Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитаар тогтоосон албан шаардлага, зөвлөмжийг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор статистик мэдээний бүртгэлийн маягтын дагуу бүртгэн баталгаажуулж, 5 хоногийн дотор Үндэсний аудитын газрын Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газарт хүргүүлэхийг Гүйцэтгэлийн аудитын ахлах аудитор (Б.Баяртогтох), Аудитор, эрх зүйч (Б.Нямсэмжаан)-д тус тус үүрэг болгосугай.

6. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Б.Баяртогтох)-д үүрэг болгосугай.



О.БАТЖАРГАЛ

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын
даргын 2026 оны 25 дугаар сарын 11 өдрийн
115 дугаар тушаалын хавсралт

Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Зөрчлийн товч утга	Албан шаардлагын дугаар	Мөнгөн дүн /сая.төг/
1	Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар Төсвийн тухай хуульд заасан шаардлагыг хангаагүй, хөрөнгө оруулалтын шинж чанаргүй, бага өртөг бүхий урсгал зардалд тусгаж болох Арвайхээр сумын гэрлэн дохио, гэрэлтүүлгийн угсралт, суурилуулалтын зардалд 50.0 сая төгрөг төлөвлөж баталсан байна.	311/A1571147/ ӨВА-2026/05- 14-ШТА-НА	50.0
2	1. Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ, ИТХ-ын ээлжит хуралдааны явцад нэмэлтээр 1,045.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ, нийт 7 ТАХ-г нэн тэргүүний ач холбогдол, төлөвлөлт, зорилгод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан эсэхийг эрэмбэлээгүй ОНХО-аар хэрэгжүүлэхээр баталсан байна. 2. Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 314.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор нэн тэргүүний ач холбогдлоор эрэмбэлэгдээгүй 4 ТАХ-нд зардал хуваарилсан байна. 3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөлтийн шаардлага хангаагүй 5 ТАХ-г төлөвлөж, баталсан байна.	312/A1571147/ ӨВА-2026/05- 14-ШТА-НА	2,359.7
3	Арвайхээр 5 дугаар сургуулийн авто зогсоол- /төсөвт өртөг 80.7 сая төгрөг / ХАА-г шаардлагад нийцсэн тендер ирээгүй тул 6 удаа зарласан бөгөөд сүүлийн тендерийг 2025 оны 6 дугаар сарын 5-ны өдөр зарлан, 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Мажестик солиушн рөүд ХХК-д гэрээ байгуулах эрхийг олгосон байна.	313/A1571147/ ӨВА-2026/05- 14-ШТА-НА	80.7
4	Баянгол сумын Засаг даргын Тамгын газарт суудлын автомашин худалдан авах тендерийг аймгийн ХААГ 4 удаа зарласан боловч шаардлагад нийцсэн тендер ирээгүй байна. Аймгийн Засаг даргын 2025 оны 5 дугаар сарын 27-ны А/383 дугаар захирамжаар ХАА-г зохион байгуулах эрхийг тухайн сумын Засаг даргад шилжүүлжээ. Баянгол сумын Засаг даргын захирамжаар үнэлгээний хороо байгуулагдан, 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдөр тендер зарлагдаж, 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Хасу бизнес групп ХХК-д 134.5 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр сонгон шалгаруулсан байна.	314/A1571147/ ӨВА-2026/05- 14-ШТА-НА	140.0
5	Хужирт сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн дотуур байрны засварын дүнг 3.5 сая төгрөгөөр илүү бүртгэсэн.	315/A1571147/ ӨВА-2026/05- 14-ШТА-НА	3.5
6	Хужирт сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн дотуур байрны засварын дүнг 3.5 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн.	316/A1571147/ ӨВА-2026/05- 14-ШТА-НА	3.5
7	Арвайхээр сумын 5 дугаар цэцэрлэгийн дээврийн засварын дүнг 65.4 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн.	317/A1571147/ ӨВА-2026/05- 14-ШТА-НА	0.1
8	Арвайхээр сумын 10 дугаар цэцэрлэгийн дээврийн засварын дүнг 65.4 дутуу төгрөгөөр бүртгэсэн;	318/A1571147/ ӨВА-2026/05- 14-ШТА-НА	0.1
Нийт дүн			2,637.5

D:\Auditiin gazar\Baiguullagiin dotood barimt\Tushaal

Холбогдох байгууллагын санал:



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 2073,

Цахим шуудан: uvurkhangai@ov.gov.mn

Цахим хуудас: www.uvurkhangai.mn

2026.05.11 № 5-3/259

танай _____-ны № _____-т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан дүгнэлтэд өгөх саналгүй болно.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА  Б.МӨНХБАТ



6226 33 0304

D:My Doc. A5 alban bichig /ZDTG/



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 2307,
Цахим шуудан: uvprocurement@ov.gov.mn,
Цахим хуудас: www.ov.hudaldan.avah.mn

2026.05.08 № 116
танай 2026.05.07 -ны № 372 -Т

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Танай газраас ирүүлсэн “Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тус тайлангийн төсөлд тусгах санал байхгүй болно.

ДАРГА



Ц.БОЛДБААТАР

622603046



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**

Өлзийтийн 1 дүгээр гудамж, 101 тоот, 8 дугаар баг,
Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62169,
Утас/факс: (976) 7032 3720,
Цахим шуудан: uvurkhangai@gazar.gov.mn,
Цахим хуудас: www.ovorkhangai.gazar.gov.mn


2026.05.11 № 252
танай 2026.05.07-ны № 371 -Т

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хяналтын тогтолцоо, захиалагчийн хяналтын үр нөлөө” сэдэвт аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн аудитын илрүүлэлтэд харьяалагдах байгууллагын нэрийг дурдаж өгнө үү
Тусгуулах санал хүсэлт байхгүй.

ДАРГА



Т.АРИУНБОЛД

622602:70

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг өгч байна.

Үүнд:

- Өвөрхангай аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй 1,268.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн нь нийт төлөвлөсөн санхүүжилтийн 10.5 хувийг эзэлж байна.
- Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ, ИТХ-ын ээлжит хуралдааны явцад нэмэлтээр 1,045.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ, нийт 7 ТАХ-г нэн тэргүүний ач холбогдол, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан эсэхийг эрэмбэлээгүй Өвөрхангай аймгийн 2025 оны төсөвт баталсан байна.
- Төлөвлөсөн ТАХ-ээс 520.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх шилжүүлсэн сумдын Засаг нар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7¹⁰-д заасан хугацааг баримтлаагүй байна.
- Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагааг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн их засварын ажлыг батлагдсан зураг төсвийн дагуу хэрэгжүүлж, автомашин, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл, арга хэмжээнүүд техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт туссан үзүүлэлт, тоо хэмжээний дагуу нийлүүлсэн байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх дараах 9 ТАХ-ний барилгын засварын ажил гүйцэтгэх гэрээнд зохиогчийн хяналтын зардалд нийт 10.6 сая төгрөгийг тусгаж өгсөн боловч тухайн ажлуудын зохиогчтой гэрээг байгуулаагүй, хяналт хийгдээгүй, санхүүжилт олгогдоогүй байна.
- Нягтлан бодох бүртгэлд 2 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг зөрүүтэй бүртгэсэн байна.

ЗӨВЛӨМЖ:

Өвөрхангай аймгийн Засаг дарга О.Пүрэвдорж танаа

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг харьяалах доод шатны төсвийн захирагчид шилжүүлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7-д заасан хугацааг баримтлах;
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний ажил гүйцэтгэх гэрээнд тусгасан төсвийн дагуу зохиогчтой гэрээ байгуулж, зохиогчийн хяналтыг сайжруулж, үр дүнтэй хэрэгжүүлэх, үүрэг хариуцлагыг тооцож ажиллах;

¹⁰ 45.7.Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх энэ хуулийн 45.1, 45.2, 45.3, 45.4-т зааснаас бусад төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг харьяалах доод шатны төсвийн захирагчид, эсхүл худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн бол ажлын 10 өдрийн дотор шилжүүлнэ.

Монгол улс, Өвөрхангай аймаг
Арвайхээр сум, Нутгийн удирдлагын ордон
Утас: +976 70323253, 70323833, 70323108
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn, цахим хуудас: www.audit.mn